

ОЛОН ҮНДЭСТНИЙ ДОХИО ЗАНГАА НЬ ЁС СУРТАХУУНЫ СОЁЛЫН ИЛЭРХИЙЛЭЛ БОЛОХ НЬ

У.Лхагвасүрэн *

Хүн төрөлхтний бодол санаагаа илэрхийлдэг бас нэгэн чухал хэл бол ямар ч үндэстний хүмүүст ижил ойлгогддог нүүр амны хөдөлгөөн, дохио зангаа юм. Дэлхийн бүх хүмүүсийн харьцааны үндсэн дохионууд ижил төстэй байдаг. Хүмүүс аз жаргалтай байвал баясан инээж, уурлавал хөмсгөө зангидан, духаа үрчийлгэж, харц нь ширүүн болдог. Толгойгоо дохивол зөвшөөрч, сэгсэрвэл эсэргүүцэж байгаагаа илэрхийлдэг нь хараагүй, дүлий хүмүүст ч хамаардаг болохоор үүнийг төрөлхийн гэж үзэж болох юм. Үүнээс гадна “мөрөө хавчих” нь юун тухай яриа болж байгааг мэдэхгүй, эсвэл ойлгохгүй байгааг илэрхийлдэг бөгөөд энэ дохио нь аль ч улс үндэстэнд түгээмэл хэрэглэгддэг дохио юм. Энэ дохио нь цогц дохио бөгөөд 3 хэсгээс бүрдэнэ: гарынхаа алгыг дэлгэж, мөрөө өргөж, мөн хөмсгөө дээш болгоно.

“За”, эсвэл “зөвшөөрлөө” гэж хэлэхийн оронд зүгээр л дуугүй толгойгоо дохиод хангалттай. Танилтайгаа тааралдаад “сайн байна уу” гэж хэлэхгүйгээр гараа сунгах эсвэл толгойгоо бөхийлгөж болдог. Тодорхой санаагаа онцлох шаардлагатай бол заримдаа долоовор хуруугаа гозойлгодог. Томоогүй, сахилгагүй хүүхдэд “боль” гэж хэлэхийн оронд мөн долоовор хуруугаа гозойлгож дохиодог. Үг хэлэхгүй байгаа ч харилцан ойлголцож чадаж байна.

Аман хэлнүүд хоорондоо ялгаатай байдгийн адил аман бус дохионы хэл ч үндэстнүүд хооронд ялгаатай байдаг. Ямар нэг дохио аль нэг үндэстэнд тодорхой тайлбартай байдаг ч нөгөө үндэстнүүдэд ямар ч утгагүй, эсвэл огт өөр утгатай байж болох талтай.

Жишээ болгон 2 дохионы үндэстнүүд хоорондын ялгааг авч үзье.

“ОК” буюу гарын хуруунуудаар дугуй үүсгэх

Энэ дохиог XIX зууны эхэн үед түгээмэл хэрэглэгддэг үг, хэлц үгийн эхний үсгүүд хүртэл нь товчлох ажлыг явуулж байсан нэг хэвлэл үүсгэсэн гэж үздэг.

Эхний үсгүүд болох О, К-ийн утгыг янз бүрээр тайлбарладаг. Жишээлбэл зарим хүмүүс энэ 2 үсгийг тайлбарлахдаа “All correct” буюу “Бүгд зөв” гэсэн утга илэрхийлдэг гэжээ. Гэхдээ дараа нь үсгийн дүрмийн алдааны дүнд “Oll correct” болсон гэж үздэг.

* МУИС, ОУХС-ийн багш, магистр

Харин зарим нь үзэхдээ "нокаут" буюу англиар "КО" үсгээр тэмдэглэдэг үгийн эсрэг утгатай гэж үзжээ. Мөн өөр нэгэн баримтаас дурьдвал: сонгуулийн өмнөх компаниг ажлынхаа лоозонд Америкийн нэгэн ерөнхийлөгч өөрийн төрсөн нутаг болох "Old kinderhood" -ийн эхний үсгүүд буюу "OK"-ийг ашиглаж байсантай холбоотой гэж үзэж байна.

Эдгээр баримт, тайлбараас аль нь үнэн зөв болохыг бид мэдэхгүй. Гэхдээ энэ дугуй нь өөрөө "О, кеу" гэсэн үгний "О" үсгийг зааж байна гэж үзэж болох юм. Энэ дохионы утга нь англи хэлтэй орнууд төдийгүй Европ, Азид ч түгсэн байдаг. Зарим орнуудад энэ зангаа нь огт өөр үүсэл гарал, утгатай юм байна. Жишээлбэл, Францад энэ нь "тэг", эсвэл "юу ч биш" гэсэн утгатай, Японд "мөнгө" гэсэн утгатай байхад Газар дундын сав газрын зарим орнуудад эрэгтэй хүнийг ижил хүйстэнтэйгээ явалддаг гэдгийг илэрхийлдэг байна.

Эрхий хуруугаа гозойлгох

Америк, Англи, Австрали болон Шинэ Зеландад эрхий хуруугаа гозойлгох нь 3 утга илэрхийлдэг. Энэ дохио зангааг гол төлөв замын машиныг зогсоохдоо хэрэглэдэг юм байна. Хоёр дахь утга нь "бүх юм хэвийн" гэсэн утга юм. Харин эрхий хуруугаа эгц дээш нь гозойлговол доромжилсон утгатай болно. Италичууд 1-5 хүртэл тоолоход эрхий хуруу нь 1-ийн тоог, долоовор хуруу нь 2-ын тоог илэрхийлдэг байхад харин Америк болон Англичууд тоолохдоо долоовор хуруунаас эхлэн тоолж эрхий хуруу нь 5-ын тоог заадаг байна.¹

Дохио зангааг хэрэглэх ёс гэж бий. Жишээлбэл, Оросод хүнийг хуруугаараа заах нь бүдүүлэгт тооцогддог. Хэрэв үнэхээр заах шаардлагатай болбол гараараа заадаг.

Оросын зохиолч Куприн хэлэхдээ гар барилцах нь тухайн хүнтэй мэндчилж байгаа төдийгүй зан төрхөө таниулж байгаа хэрэг гэжээ. Үнэхээр гар барилцах ёс нь өөрийн асар том өвөрмөц онцлогтой ажээ. Түүний нэгэн зохиолын баатрын хэрхэн мэндчилж байгаа, гараа яаж байлгаж байгаа, гар барихдаа хэрхэн чанга, сул байгаа, хэр тонгойж байгааг зохиолч өнгөцхөн дурдсан байхад л уншигчид нэг бүрчлэн дүрслэн тайлбарласнаас илүү дүрийн онцлог зан чанар, төлөвийг тод харж чадаж байлаа. Жишээлбэл, хоёр хуруугаа өргөх нь ихэмсэг дээдсийн мэндчилгээ, гар завь хэлбэртэй болгон сунгах нь ичиж зовсон хүний мэндчилгээ, мөн хүний гарыг тавихгүй удаан барих нь тухайн хүнд найз нөхрийн үүднээс, эсвэл эрээ цээргүй хандаж байгаагийн илрэл гэж үздэг ажээ.²

Төдийлөн дохиж зангаад байдаггүй бусад улс орнуудын хувьд оросууд харилцахдаа дохио зангааг маш өргөн дэлгэр хэрэглэдэг бөгөөд дорно зүгийн театрын жүжигчид орос жүжиг тоглохдоо оросуудаас илүү гараа гозгонуулан дохидог байна. Тэд оросуудын дохио зангааг хэрхэн яаж, ямар үед хэрэглэдгийг мэдэхгүй эсвэл ойлгохгүй болохоор өөрсдийнхөөрөө хүлээн авч тэр л хэмжээндээ үзүүлдэг байна. Гэтэл оросуудын гараараа даллах дохио зангаа нь зан авир, үндэсний онцлог, биеэ авч явах хэм хэмжээ, хүйс зэргээсээ шалтгаалан янз бүр байдаг. Гэхдээ дохиж зангахдаа оросууд гараа хэтэрхий их урагш

¹ "Язык телодвижений" Нижний Новгород. 1992. Аллан Пиз.

² "Психология общения" Ярославль 1979. Ерастов. Н.П.

сунгадаггүй, биеэсээ ч их холдуулдаггүй, мөн тохойгоо биерүүгээ татаж гараа өгдөггүй онцлогтой юм байна. Оросууд дохиж зангахдаа бусад улсуудтай харьцуулахад хоёр гараа зэрэг хөдөлгөдөггүй зөвхөн баруун гараар дохиж зангадаг байна. Харин зүүн гар нь огт дохиж зангадаггүй ба бага зэрэг хөдөлж болохоос гадна нөгөө гарынхаа хөдөлгөөнийг давтдаггүй байна.

Гарын хөдөлгөөнийг ихэвчлэн толгой юм уу мөр орлодог. Жишээлбэл, чиглэл заахдаа гараа дохихгүй бол толгойгоороо явах зүг рүү дохидог. Харин мэдэхгүй гэж хэлэхийн оронд мөрөө хавчдаг байна.

Ер нь оросууд дохиж зангаж байх үед бусад орны хүмүүс төдийлөн утгыг ойлгож чаддаггүй бөгөөд хэзээ хаана хэнтэй хэрхэн дохиж зангаж байгааг ч тэр бүр ойлгоход бэрх байдаг ажээ. Оросуудын дохиж зангах, нүүрний хувьсал өөрчлөлт зэрэг нь тухайн нөхцөл, хүмүүсийн хоорондын харьцаа, мөн тэдний нийгэмд эзлэх байр сууринаас шалтгаалдаг байна. Хүн хэдийчинээ их боловсон, хүмүүжилтэй байна, төдийчинээ их дохио зангаа хэрэглэдэг ажээ. Дохио зангааны эрчтэй байгаа эсэхээс харилцагч хүнийхээ сэтгэл хөдлөлийн байдлыг илрүүлж болдог ажээ.

Гадаад хэлийг ойлгохгүй бол хүн ихэвчлэн дохио зангаагаар нь утгыг нь "унших"-ыг оролддог. Гэвч тухайн хэлнийхээ үндэсний онцлогийг мэдэхгүйгээр тэр бүр зөв "уншиж" чадахгүй л болов уу. Жишээлбэл, дорно зүгийн орнуудад очсон оросуудад тэдгээр нутгийн хүмүүс хүйтэн хөндий сэтгэгдэл төрүүлдэг байна. Харин тэр нутгийн хүмүүс оросуудыг хэтэрхий хурдан дотносох, нөхөрлөхийг хүсдэг хэмээн тодорхойлжээ. Энэ нь тэдгээр ард түмнүүдийн хоорондоо харьцах харьцааны онцлогоос шалтгаалсан зүйл юм. Орос хүмүүс хоорондоо ярьж байхдаа дорно зүгийн хүмүүсийг бодвол ойрхон зайтай зогсдог бол испаничуудыг бодвол хол зайнаас харьцдаг ажээ.³

Орос хүмүүс албан ёсны харилцааны үед гар барилцахаар сунгасан 2 гарын урттай тэнцэх зайтай байдаг ба найз нөхрийн харьцааны үед тохойгоор нугалсан хоёр гарын хэмжээтэй зайнаас харьцдаг ажээ. Гараа атгалцаж мэндэлдэггүй ард түмний хувьд хоорондын зай нь оросуудын албан ёсны харьцааны зайнаас ч хсл, өөрөөр хэлбэл, бөхийх зайтай байх ёстой ажээ. Мэдээж ийм зайнаас харьцах нь орос хүмүүсийн хувьд хэтэрхий хөндий хүйтэн харьцаа болно.

Дорно зүгийн хүмүүс европчуудтай (оросуудтай) харьцах үедээ гар барьж мэндэлдэг бөгөөд харин хоорондын зайг өөрсдийнхөөрөө барьдаг байна.

Харин монголчууд зочин угтаж үдэх үедээ харилцан алга хавсарч мэхийх, гар өргөн ёслох хийгээд гар барилцаж болно. Харин тэврэлдэх нь бараг үгүй. Зочныг угтаж үдэхдээ монгол хүмүүс ихэд дотно аав, ээж, ах, эгч нараа үнсэж болно. Эцэг, эх, ах, эгч нь хүүхэд, дүү нарынхаа нэг хацрыг угтахад, нөгөөг нь үдэхэд үнсдэг. Анд нөхөд учрах болон үдэлцэхэд үнсэлцэж болох авч олны дунд ингэхийг монголчууд нэг их таашаадаггүй. Монгол эрчүүд хоорондоо үнсэлцэх нь бараг үгүй.

Бөхийн мэндлэх ёс нь эртний Орос улсад их өргөн дэлгэрч байжээ. Энэ ёс нь олон хувилбартай бөгөөд заримаас нь дурьдвал гараа зүрхэндээ наан урагш бөхийгөөд дараа нь гараа биеэ дагуулсан байдалтайгаар унжуулах хэлбэр байдаг. Энэ ёсоор хамгийн хүндтэй хүмүүсээ угтаж, үддэг байжээ.

³ "Некоторые аспекты исследования невербальной коммуникации у человека" Краснадор 1979. Ковалев.Г.А

Хэдийчинээ урагш бөхийнө, төдийчинээ хүндэлж байгаагийн илрэл ажээ. Монголчууд эртнээс хүндтэй хүндээ сөгдөж, мөргөж мэндчилдэг байсан.

Монголчуудын сөгдөж мөргөж мэндчилэх ёсны тухай товч дурьдъя. Эрэгтэй хүн бол баруун хөлөө сөгдөж, зүүн хөлөө цомцойн, хоёр гараа цомцойсон өвдөг дээрээ тавьж цээжин биеэ бөхийсхийж амар эрдэг. Эмэгтэй хүн бол зүүн хөлөө сөгдөж, баруун өвдгөө цомцойн хоёр гараа өвдөг дээрээ тавьж цээжин биеэ бөхийсхийж амар эрдэг. Мөргөхдөө эрэгтэй хүн бол хоёр өвдгөөр сөгдөж, хоёр гараа хоёр талаас урагш авчран өвдөгний өмнө нийлүүлж найман хурууны үзүүр газар хүрэхэд цээжин бие толгойгоо бөхийсхийн мөргөдөг. Эмэгтэй хүн баруун хөлөө сөгдөж, зүүн хөлөө цомцойн зүүн гараа доргош тавьж баруун гарын таван хуруугаа дэлгэж, баруун санчиг өөд өргөхөд толгойгоо хурууны үзүүр тийш хазайсхийн дохиж мөргөдөг.⁴ Орчин үед ингэж мэндлэх нь бараг үгүй болсон бөгөөд гараа барилцах ёс дэлгэрсэн. Харин гар барилцахдаа бие нь эсвэл толгой нь үл ялиг урагш тонгойсон байх ба харц нь харилцагч хүн рүү чиглэсэн байдаг байна. Нүдний харц доошоо, толгой бөхийсөн байх нь тухайн хүн ямар нэгэн зүйлд буруутай, эсвэл ичсэн байдалтай байгаагийн шинж гэж үздэг юм байна. Хүний харц яриатай, түүний утгатай нягт холбоотой бөгөөд холбоо тогтоох хэрэглүүр болдог. Гэхдээ үндэстнүүдийн хувьд харцыг янз бүрээр ойлгож ашигладаг. Орчин үеийн угсаатны зүйч эрдэмтэд харцыг чиглэж байгаа байдлаас нь шалтгаалж хоёр соёл иргэншилд ангилсан.

Нэг хэсэг хүмүүсийн харц харилцаж байгаа хүнийхээ нүд рүү чиглэсэн байхад (Арабчууд, Латин Америкчууд, Европчууд) зарим хүмүүст нүд рүү нь эгцэлж харах нь бүдүүлэг учир өөр тийш харцаа чиглүүлдэг байна. Ийм хоёр хүнийг хооронд нь уулзуулахад харцыг өөрсдийнхөөрөө ойлгоно. Дорно зүгийн ихэнх улсуудад оросуудын нүд рүү эгцэлж харах нь бүдүүлэг, хэрцгий, эрээгүй санагддаг байхад тэдний өөрсдийнх нь өөр тийш харах нь оросуудад ичимтгий, эсвэл илэн далангүй байхаас татгалзаж байгаагийн шинжийг илтгэдэг. Үүнээс үзэхэд хүмүүсийн хоорондын харилцаа аман бус түвшинд үүсч тогтож болохоос гадна мөн харьцааны энэ л хэлбэрээс янз бүрийн соёл иргэншлийн хүмүүс бие биеэ ойлгохгүйд хүрдэг байна.

Мөн оросууд европчууд болон дорнын улсуудыг бодвол бие биендээ хүрч харьцах нь их байдаг. Жишээлбэл, оросууд япончуудыг бодвол хүүхдээ гараас нь хөтөлж явах нь их байдаг. Орос залуучууд бүсгүйчүүд зугаалахдаа гар гараасаа хөтөлж явах дуртай байдаг. Мөн орос эмэгтэйчүүд гараа барилцан явах нь гадаад хүмүүсийн гайхлыг ихэд төрүүлдэг. Мөн оросод эрэгтэй найзууд бие биеэ тэврэн үнсэж мэндлэх нь элбэг тохиолдоно. "... Как вожделенно жаждёт век. Нашупатв брешь у нас в цепочке. Водьмёмся за руки, друзья, чтоб не пропасть поодиночке..." (Б.Окуджава Союз Друзей)

Энэтхэг, Хятад, Индонез үндэстнүүдийн үзэж байгаагаар оросууд тэврэлдэн үнсэлцэх нь маш элбэг бөгөөд харин испаничууд, италичуудыг бодвол маш бага гэнэ. Орос хүмүүс албан ёсны харилцааны үед гараа барилцдаг бөгөөд албаны бус энгийн харьцааны үед ихэвчлэн харилцагч хүндээ хүрч харьцдаг ажээ. Хэн нэгний анхаарлыг өөртөө татахын тулд хурууных нь үзүүрээс барих, хэрэв нууц зүйлийн тухай ярихыг хүсвэл сугадаж явах нь элбэг ажээ. Ярьж байх үедээ орос эрчүүд бие биенийхээ мөр лүү

⁴ "Монгол ёс заншлын их дунд бага тайлбар толь" УБ 1975. Х.Нямбуу, Ч.Арьяасүрэн

алгадан найз нөхрийн хувьд талархаж явдгаа илэрхийлдэг байна. Энэ нь зөвхөн найз нөхдийн хүрээний асуудал бөгөөд бусад тохиолдолд үүнийг эрээ цээргүй гэж үздэг юм байна.⁵ "...Душевио рад познакомиться. Дайте пожать мне вашу руку. – Чичиков дал ему обе." (Н.Гоголь. Мёртвые души) "...Эй товарищ! Гэснээ эрхий хуруугаа гозойлгон баруун гараа хэдэнтээ өргөж мэндийг нь мэджээ. Цаадах орос нь хариу эрхий хуруугаа гозойлгон талархалтайгаар толгой дохиж байв..." (С.Дашдооров. Сономын нэгэн баяр).

Энд орос үндэсний үнсэх ёсны тухай дурьдахгүй өнгөрч болохгүй болов уу. Удаан хол байгаад уулзахдаа, эсвэл салах ёс хийхдээ, мөн дотны найз ойрын хамаатнууддаа баяр хүргэж орос хүмүүс 3 удаа үнсдэг байна. Ингэхдээ толгойгоо баруун-зүүн-баруун, зүүн-баруун-зүүн чиглэлээр эргүүлдэг байна. Харин энэ ёсыг орчин цагт оросууд тэр болгон хэрэглэхээ больжээ. Мөн эмэгтэй хүний гарыг үнсэх ёс байна. Энэ нь орчин үед өдөр тутамд бараг хэрэглэгдэхээ больсон бөгөөд зөвхөн баяр ёслолын үед ахмад настай эмэгтэй хүнтэй мэндлэхдээ, мөн дээдсийн хүрээнд хэрэглэгддэг ажээ.

Олон үндэстнүүдийн соёл иргэншил, зан заншлын өвөрмөц онцлогийг танин мэдэж ойлгоход, мөн улс төр, арилжаа бизнесийн салбарт дохионы хэлийг судлан хэрэглэхэд хэлний бус хэрэгсэл дохио зангаа нь гол үүрэг гүйцэтгэдэг.

⁵ "Жест и мимика в обучении эмоциональным интонациям" Москва, 1980. Муханов. И.Л